

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ 2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 03 дугаар сарын 29

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Засгийн газрын 2009 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагын үйл ажиллагааны “Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/122 дугаар тушаалаар баталсан “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг тус тус баримтлан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2017 оны үйл ажиллагаанд жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үр дүнд үнэлэлт дүгнэлт өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 бодлогын баримт бичиг, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл зэрэг бодлогын баримт бичгүүдэд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар тусгагдсан зорилт арга хэмжээ, УИХ, Засгийн газраас баталсан тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, гадаадын зээл тусламж болон улсын төсвийн санхүүжилтээр салбарт хэрэгжиж буй хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилт, Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагч /ерөнхий менежер/-тай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт, яамны 2017 оны үйл ажиллагааны тайлан, бусад мэдээ материалд тулгуурлан Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын дагуу 3 багц, 8 үзүүлэлтээр дүгнэв.

Байгууллагын шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээг Сангийн яамнаас, шударга байдлын түвшний үнэлгээг Авлигатай тэмцэх газраас тус тус гаргаж ЗГХЭГ-т хүргүүлдэг тул үнэлгээнд оруулаагүй болно.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн биелэлтийн 2016 онд хүрсэн бодит үр дүнг хүрвэл зохих үр дүнгийн түвшинтэй харьцуулан хувиар тодорхойлж үнэлгээг гаргахад ерөнхий үнэлгээ **89,3%** буюу **4,46** оноотой байна.

I. БОДЛОГЫН ЗОРИЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДҮН.

1.1. ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд холбогдох хууль тогтоомж, тогтоол шийдвэр /эрх зүйн акт/-ийг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 8.1. дэх хэсэгт заасны дагуу хяналтанд авч, салбар, чиглэлээр нь 5 ангилж хяналт шинжилгээ, үнэлгээг хийв. Хяналтанд авсан эрх зүйн актыг агуулгаар нь 5 ангиллаар хэрэгжилтийг гаргуулж, нийт 156 шийдвэрийн 226 заалтад хяналт шинжилгээ, үнэлгээ хийж нийт дүнгээр **90,6%**-ийн биелэлттэй дүгнэв.

Эдгээрт Геологи, эрдэс баялгийн бодлогын 7 шийдвэрийн 9 заалтын хэрэгжилт 100.0%, Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлогын 16 шийдвэрийн 21 заалтын хэрэгжилт 83,5%, Уул уурхайн бодлогын 43 шийдвэрийн 58 заалтын хэрэгжилт 81.0%, Хүнд үйлдвэрийн бодлогын 33 шийдвэрийн 43 заалтын хэрэгжилт 85.7%, Нийтлэг асуудлын 57 шийдвэрийн 95 заалтын хэрэгжилт 98.0 хувийн тус тус биелэлттэй дүгнэв.

ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ

/Салбар, чиглэлээр/

№	Ангилал	Шийдвэр	Заалт	Үнэлгээ /%/
1	Геологи, эрдэс баялгийн бодлого	7	9	100
2	Газрын тос, газрын тосны бүтээгдэхүүн болон түүний нөөцийн талаарх бодлого	16	21	83,5
3	Уул уурхайн бодлого	43	58	81,0
4	Хүнд үйлдвэрийн бодлого	33	43	85,7
5	Нийтлэг асуудлын	57	95	98,0
Нийт дүн		156	226	90,6

Нийт 226 заалтын 41 заалт үнэлэх боломжгүй, хэрэгжилт гаргаж дүгнэсэн 185 заалтын 135 заалт буюу 73,0% бүрэн биелсэн, үлдсэн 50 заалт буюу 27,0% хэрэгжилтийн шатанд буюу 30-70 хувийн биелэлттэй байна.

Эдгээрт 7 хуулийн 10 заалт 74,3, УИХ-ын 8 тогтоолын 11 заалт 88,7, УИХ-ын байнгын хорооны 10 тогтоолын 25 заалт 95,7, Ерөнхийлөгчийн 3 зарлигийн 3 заалт 100, Засгийн газрын 61 тогтоолын 78 заалт 87,9, Засгийн газрын 51 хуралдааны тэмдэглэлийн 63 заалт 93,7, Ерөнхий сайдын 8 захирамжийн 8 заалт 87,1, ҮАБЗ-ийн 7 зөвлөмжийн 17 заалт 89,2, ҮАБЗ-ийн 7 шийдвэрийн 17 заалт 89,2%-ийн тус тус хэрэгжилттэй байна.

ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ

/2017 оны жилийн эцэс/

		Бүгд	Монгол улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Ерөнхий сайдын захирамж	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, тэмдэглэл	Засгийн газрын албан даалгавар
Хяналт анд авсан	Шийдвэрийн тоо	156	7	8	10	3	61	51	8	7	1
	Зүйл, заалтын тоо	226	10	11	25	3	78	63	8	17	11
Үүнээс	Биелсэн 100%	135	1	5	18	2	45	42	4	9	9
	Хэрэгжих шатанд	91	9	6	7	1	33	21	4	8	2
	70.0%	44	6	3	3	-	11	11	3	5	2
	30.0%	6	-	-	-	-	6	-	-	-	-
	Хэрэгжээгүй /0%/	-	-	-	-	-	-	-	-	-	-
	Дүгнэгдээгүй	41	3	3	4	1	16	10	1	3	-
Хэрэгжилтийн дундаж /%/		90,6	74,3	88,7	95,7	100	87,9	93,7	87,1	89,2	94,5

Үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/143 тоот албан бичгээр ХЭГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 8.6-д заасны дагуу, цаг хугацааны хувьд ач холбогдолгүй болсон, бүрэн хэрэгжсэн, тухайн асуудлаар дахин шийдвэр гарсан нийт 102 шийдвэрийн 129 заалтыг хяналтаас хасуулах саналыг тайлангийн хамт ЗГ-ын ХЭГ-т хүргүүлж ажиллав.

1.2. ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ.

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан 36 зорилтын 105 арга хэмжээ, үүнээс 76 арга хэмжээг толгойлон, 28 арга хэмжээг хамтран, 1 арга хэмжээг оролцогчоор хэрэгжүүлэхээр тусгагдсаныг хяналтанд авч сайдын 2017 оны А/22 дугаар тушаалаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Жилийн эцсийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний unelgee.gov.mn цахим системд байршуулсан 28 зорилтын 85 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Биелэлт гаргасан 85 арга хэмжээнээс 65 арга хэмжээг яам толгойлон, 20 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлжээ.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлогын хүрээний 1 зорилтын 3 арга хэмжээний биелэлт 60.0 хувь, Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын хүрээний 22 зорилтын 73 арга хэмжээний биелэлт 69,5 хувь, Нийгмийн бодлогын хүрээний 1 зорилтын 1 арга хэмжээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй, Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын 4 зорилтын 8 арга хэмжээний биелэлт 60,0 хувь, хэрэгжүүлсэн нийт 85 арга хэмжээний биелэлтийг 68,4 хувьтай дүгнэлээ.

Үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02/208 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЯВЦЫН ҮНЭЛГЭЭ

/2017 оны жилийн эцэс/

Зорилт	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь, арга хэмжээний тоо					Хэрэгжилт /хувь/
			100	70	40	0	/-/	
Нэг. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах онцгой бодлого	1	3		2	1			60,0
Хоёр. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	22	73	19	27	20		7	69,5
Гурав. Нийгмийн бодлого	1	1					1	/-/
Дөрөв. Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	4	8		4	2		2	60,0
Дүн	28	85	19	33	23		10	68,4

Үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийг хэрэгжүүлэх он тус бүрээр үзүүлэв.

Хэрэгжүүлэх он	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн дундаж, %	
		2017 хагас жил	2017 жилийн эцэс
2017	13	64,0	65,0
2016-2017	15	76,9	87,1
2016-2018	2	40,0	40,0
2016-2019	5	40,0	52,0
2016-2020	29	54,3	68,8

2017-2018	7	52,8	70,0
2017-2020	14	33,0	56,3

1.3. ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний 2017 оны жилийн эцсийн биелэлт 88,4 хувьтай байна. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс 17 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн, 8 арга хэмжээ 70 хувь, 1 арга хэмжээ 40 хувийн тус тус хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй.

Үндсэн чиглэлийн жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхтэй холбогдуулан хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг нотлох баримтанд тулгуурлан журмын дагуу үнэлгээний оноог өгөв.

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТОВЧОО

/2017 оны жилийн эцэс/

Бодлого	Зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний биелэлт, хувиар					Дундаж, %	
			100	70	40	0	/-/	Жил ийн эцэс	Хагас жил
НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО	Нутаг дэвсгэрийн геологийн тогтоц, ашигт малтмалын тархалтын зүй тогтол, хэтийн төлвийг судлах зорилгоор геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлыг үргэлжлүүлэх	9	7	2				93,3	73,3
	Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх, Тавантолгойн орд ашиглах болон хөрөнгө оруулалтын гэрээ, хэлцлийг байгуулж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэх	4	2	2				85,0	47,5
	“Алт-2” хөтөлбөрийг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх	3	3					100	100,0
	Ашиглахад бэлэн болсон уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх, олборлолт, экспортыг нэмэгдүүлэх	1	1					100	70,0
	Хүнд аж үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх	7	4	2	1			82,8	70,0
	Газрын тосны эрэл, хайгуул, олборлолтыг тогтвортой нэмэгдүүлж, газрын тос боловсруулах үйлдвэрийг барих бэлтгэл ажлыг хангах	2		2				85,0	85,0
Нийт дундаж		26	17	8	1			88,4	72,3

Үнэлгээний тайланг яамны удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулж, тайланг 2018 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 02/199 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлж, дүнг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нэгдсэн систем www.unelgee.gov.mn сайтад байршуулав.

1.4. ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд геологийн зураглал, голлох эрдэс түүхий эдийн олборлолт, экспорт, газрын тосны бүтээгдэхүүний импорт, металл, шатах ашигт малтмалын үйлдвэрлэлийн 9 ангиллын 21 үзүүлэлтийг Засгийн газрын 2018 оны 55 дугаар тогтоолоор баталсан. Тайлант хугацаанд 8

ангиллын 20 үзүүлэлтийн 10 үзүүлэлт зорилтот түвшнээс өссөн, 7 үзүүлэлт зорилтот түвшнээс буурсан гүйцэтгэлтэй байна.

Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт, голлох эрдэс түүхий эдийн зэсийн баяжмал олборлолт, газрын тос, зэсийн баяжмалын экспорт, ОХУ-аас импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ, дизель түлш, автобензин, мазут, ган бүтээгдэхүүн үйлдвэрлэл тус тус өссөн, газрын тос, төмрийн хүдрийн олборлолт, нүүрс, төмрийн хүдэр, алтны экспортын хэмжээ, бусад улсаас импортолсон газрын тосны бүтээгдэхүүний хэмжээ, катодын зэсийн үйлдвэрлэл зорилтот 2017 оны түвшинд тус тус хүрээгүй байна.

Улсын хэмжээнд 2017 онд 7,632.6 мянган баррель тос олборлосон нь зорилтот түвшинтэй харьцуулахад 96 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэ нь зорилтот түвшинээс 4 хувиар бага байгаа бөгөөд газрын тос олборлолтын төлөвлөгөөний биелэлтэнд дараах хүчин зүйлс нөлөөлсөн. Үүнд:

1. Газрын тосны олборлолт, тээвэрлэлт явагдаж буй Дорнод аймгийн Матад, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумдад малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан 2017 оны 02 сарын 21-нээс 03 сарын 09-нийг хүртэл 14 хоног экспортын үйл ажиллагааг зогсоосон.
2. Дорнод аймгийн ИТХ-ын 2017 оны 83 дугаар тогтоол, Засаг даргын А/435 дугаар захирамжаар Тамсаг-XXI талбайгаас экспортын тээвэрлэлтийг иргэд болон мал сүргийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна гэж үзэн тээвэрлэлтийн 68 км авто замыг хатуу хучилттай болгох шаардлага тавьж 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдрөөс 29-ний өдрүүдэд 7 хоног экспортын үйл ажиллагааг зогсоосон.
3. Зүүн бүсийн эрчим хүчний хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдон Чойбалсангийн ДЦС-аас Тосон-Уул XIX, Тамсаг XXI талбайнуудад 2017.07.15-наас хязгаарлалт /шаардлагатай 20МВт-аас 15,5МВт-аар/ тогтоосон нь олборлолт, экспортын үйл ажиллагаанд нөлөөлсөн байна.

Монгол улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ зорилтот түвшинтэй харьцуулахад давж биелэгдсэн боловч ОХУ-аас бусад улсаас импортлох бүтээгдэхүүний хэмжээний гүйцэтгэл 86 хувийн биелэлттэй байна. Үүний гол шалтгаан нь БНХАУ болон бусад улсаас худалдан авах газрын тосны бүтээгдэхүүний импортын үнэ өндөр байсантай холбоотой байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар **97,0** хувьтай, 4.9 оноогоор дүгнэв.

ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТ

/2017 оны жилийн эцэс/

№	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2016/	Эхний жил /2017 он/					
			Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Өөрчлөлт	Үнэлгээ		
						Хувь	Оноо	
1	Монгол Улсын нутаг дэвсгэрийн геологийн 1:50 000-ын масштабын зураглал, ерөнхий эрлийн ажилд хамрагдалт (хувь)	34.6	37.0	37.4	0.4	101	100	5.0
2	Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд геологийн 1:200000-ын масштабын иж бүрэн зураг зохиох төслийн хэрэгжилт (бүх нутгийг хамарсан байх)	86.0	100.0	100.0	0.0	100	100	5.0
3	Голлох эрдэс түүхий эдийн олборлолтын хэмжээ							
	Газрын тос (мянган баррель)	8,249.8	7,971.1	7,632.6	-338.5	96	96	4.8
	Нүүрс (сая тонн)	35.4	47.1	47.1	0.0	100	100	5.0
	Зэсийн баяжмал (мянган тонн)	1,445.1	1,310.0	1,317.1	7.1	101	100	5.0
	Төмрийн хүдэр (сая тонн)	4.9	10.0	7.7	-2.3	77	77	3.9
	Алт (тонн)	18.4	19.8	19.8	0.0	100	100	5.0
4	Голлох эрдэс түүхий эдийн экспортын хэмжээ							

	Газрын тос (мянган баррель)	8,015.9	7,100.0	7,514.2	414.2	106	100	5.0
	Нүүрс (сая тонн)	25.7	33.4	33.0	-0.4	99	99	4.9
	Зэсийн баяжмал (мянган тонн)	1,562.0	1,280.0	1,607.8	327.8	126	100	5.0
	Төмрийн хүдэр (сая тонн)	6.1	7.0	6.3	-0.7	90	90	4.5
	Алт (тонн)	19.2	15.0	14.6	-0.4	97	97	4.9
5	Газрын тосны бүтээгдэхүүний импортын хэмжээ (сая тонн)	1.22	1.49	1.50	0.01	101	100	5.0
	Үүнээс: ОХУ-аас	1.16	1.44	1.46	0.02	101	100	5.0
	Бусад улсаас	0.06	0.05	0.04	-0.01	86	86	4.3
6	Газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл (мян. тн)							
	Дизель түлш	30.0	30.0	32.0	2.0	107	100	5.0
	Автобензин	15.0	15.0	20.0	5.0	133	100	5.0
	Мазут	5.0	5.0	10.0	5.0	200	100	5.0
7	Ган бүтээгдэхүүн (мянган тонн)	40.0	50.0	60.0	10.0	120	100	5.0
8	Катодын зэс (мянган тонн)	15.0	15.0	14.6	-0.4	97	97	4.9
9	Ангжруулсан төмөр (мянган тонн)	/-/	/-/					
ЭЗНХҮ-ийн биелэлтийн ерөнхий үнэлгээ							97,0	4.9

Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

II. БАЙГУУЛЛАГЫН ЧИГ ҮҮРГИЙН ҮЗҮҮЛЭЛТ.

2.1. БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙН ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь 2017 онд 7 стратеги зорилтын хүрээнд нийт 307 арга хэмжээ /ажил үйлчилгээ/ төлөвлөж хэрэгжүүлснээс төлөвлөгөөний биелэлт, хүрсэн түвшинд хийсэн үнэлгээгээр гүйцэтгэл **98,8%**-тай дүгнэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт

№	Стратегийн зорилт	Арга хэмжээний тоо	Үнэлгээ %
1	Стратегийн зорилт 1. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагаар хангах, аппаратын дотоод зохицуулалт, үйлчилгээг эрхлэх, гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд бүх талын дэмжлэг үзүүлэх;	91	92,8
2	Стратегийн зорилт 2. Геологийн талаарх хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах;	67	94,0
3	Стратегийн зорилт 3. Уул уурхайн салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах бодлогын шинжилгээ хийх, бодлогын удирдамжаар хангах;	63	93,0
4	Стратегийн зорилт 4. Түлш, газрын тосны салбарын хууль, тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар, төсөл боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;	56	91,9
5	Стратегийн зорилт 5. Хүнд үйлдвэрийн салбарын хууль тогтоомжийн төсөл, бодлого, хөтөлбөрийн хувилбар боловсруулах, бодлогын удирдамжаар хангах;	55	88,1
6	Стратегийн зорилт 6. Хууль тогтоомж, бодлогын дүн шинжилгээ хийх, бодлого, хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах;	59	91,0
7	Стратегийн зорилт 7. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийх, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн аудит хийх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах;	81	96,8
Дундаж үнэлгээ			98,8

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ.

Төсвийн ерөнхийлөн захирагч, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Ц.Дашдорж, Төсвийн шууд захирагч, Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал нарын байгуулсан 2017 оны Үр дүнгийн гэрээний хавсралт, яамны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийтдээ 307 ажил үйлчилгээ, төлөвлөгдсөн.

**Төсвийн шууд захирагчийн 2017 оны Үр дүнгийн гэрээний
биелэлтэд өгсөн оноо**

Үр дүнгийн гэрээний үзүүлэлт	Өгвөл зохих оноо	Гэрээний биелэлтэд өгсөн оноо	
		ХШҮДАГ	ТШЗ
1. Нийт бүтээгдэхүүний нийлүүлэлт	0-30	29,2	29,2
2. Тусгай захиалгат бүтээгдэхүүний нийлүүлэлт	0-40	39,3	39,3
3. Манлайллыг хэрэгжүүлэх зорилтын биелэлт	0-30	30,0	30,0
Нийт оноо	0-100	98,5	98,5

**Төсвийн шууд захирагчийн 2017 оны Үр дүнгийн гэрээний биелэлт
/хувиар/**

№	Арга хэмжээний нэр	Төлөвлөсөн ажлын тоо	Төлөвлөгөөний биелэлт, хувь							/-/	Биелэлт %-аар/	Оноо
			100%	90%	70%	50%	30%	10%	0%			
1	Нийт бүтээгдэхүүн нийлүүлэлт	160	81	55	12	5	2			5	97,3	29,2
2	Тусгай захиалгат бүтээгдэхүүн нийлүүлэлт	139	71	28	20	7	7	1		5	98,3	39,3
3	Мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилт	8	8								100	30,0
Дүн		307	160	83	32	12	9	1		10	98,8	98,5

Төсвийн шууд захирагчаас 2017 онд Төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлбэл зохих нийтдээ 307 ажил үйлчилгээ төлөвлөснөөс үнэлгээ өгсөн 299 ажил үйлчилгээ 92,7%-ийн биелэлттэй, 92,1 оноог өгч 10 ажил үйлчилгээний биелэлтэд үнэлгээ өгөөгүй болно.

Хэрэгжүүлсэн 289 ажлын 160 /55,3%/ нь тавьсан зорилгодоо бүрэн хүрсэн 100%-ийн;

83 ажил /28,7%/ нь зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, гол үр дүн нь гарч эхэлсэн буюу 90%-ийн;

32 ажил /11,0%/ нь гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа буюу 70 хувийн;

22 ажил /7,6%/ нь бэлтгэл болон боловсруулалтын ажил хийгдэж тодорхой хэмжээнд ажил нь эхэлсэн буюу 10-аас 50 хувийн тус тус биелэлттэй дүгнэлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас Төсвийн шууд захирагчийн 2017 оны Үр дүнгийн гэрээний жилийн эцсийн биелэлтэд 92,1 оноогоор “А” буюу “маш сайн” үнэлгээг өгөв.

2.2. ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ.

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ нийх нийтлэг журам”-ын 10 дугаар хавсралтаар захиргааны байгууллагын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагаа, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг баталсан.

Тус журмын 6.7.-д, ... хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын биелэлт, ... үйл ажиллагааг үнэлэхдээ хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг тооцдог аргачлалыг баримтална гэж заасны дагуу хүний нөөцийг чадавхжуулах 2 зорилт, албан хаагчдын нийгмийн баталгааг хангах 3 зорилтын нийт 10 шалгуур үзүүлэлтийн биелэлтийг гаргуулж үнэлгээг өгөв.

Хяналт-шинжилгээ, үнэлгээгээр яамны хүний нөөцийн тогтвор суурьшилыг хангах шалгуурын хэрэгжилтийг **100%**-тай дүгнэв.

Яамны 2017 оны төсөвт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах төсөв батлагдаагүй учир 2 шалгуурын биелэлтэд үнэлгээ өгөөгүй болно.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ТОГТВОР СУУРЬШИЛЫГ ХАНГАХ ШАЛГУУРЫН БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

/2017 оны жилийн эцэс/

№	Шалгуур үзүүлэлт	Заалт	Дүгнэсэн арга хэмжээний биелэлт, /%/					Биелэлт /%/
			100	70	30	0	Дүгнээгүй	
1	Хүний нөөцийг чадавхжуулах	4	4	-	-	-		100
2	Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	6	4	-	-	-	-	100
Хэрэгжилтийн дундаж		10	8	-	-	-	2	100

Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах зорилтын биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний танилцуулгыг хавсаргав.

III. БАЙГУУЛЛАГЫН НЭЭЛТТЭЙ БАЙДАЛ.

3.1. БАЙГУУЛЛАГЫН ИЛ ТОД БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ.

Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай Засгийн Газрын 2009 оны 143 дүгээр тогтоолын хавсралтад Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг илтгэх 10 шалгуур, Хүний нөөцийн ил тод байдлыг илтгэх 7 шалгуур үзүүлэлтийг баталсан.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ нийх нийтлэг журам”-ын 11 дүгээр хавсралтаар үйл ажиллагааны ил тод байдлын 9, хүний нөөцийн ил тод байдлын 5 үзүүлэлтээр биелэлтийг гаргуулж үнэлгээг өгөв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн 2017 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр нийт шалгуур үзүүлэлтүүдийн биелэлт 100 хувийн биелэлттэй, дундаж нь **100%**-тай дүгнэв.

Яамны хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ажил үйлчилгээ байхгүй тул үнэлгээ өгөөгүй /-/ , хүний нөөцийн стратеги, түүний

хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх үзүүлэлтийн биелэлтэд 100 хувийн үнэлгээг тус тус өгөв.

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН БИЕЛЭЛТЭД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ

/2017 оны жилийн эцэс/

№	Шалгуур үзүүлэлт	Заалт	Биелэлт, %/				Дүгнээгүй	Биелэлт %/
			100	70	30	0		
1	Үйл ажиллагааны нээлттэй байдал	9	8	-	-	-	1	100
2	Хүний нөөцийн ил тод байдал	5	5	-	-	-	-	100
Хэрэгжилтийн дундаж		14	13	-	-	-	1	100

Ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд хийсэн үнэлгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

3.2. ШИЛЭН ДАНСНЫ ХӨТЛӨЛТИЙН ҮНЭЛГЭЭ.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9.10-т, шилэн дансны хөтлөлтийн үнэлгээг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргаж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 4 дүгээр сарын 1-ний дотор хүргүүлнэ гэж заасны дагуу Сангийн яамнаас нэгдсэн үнэлгээ хийгдэх тул яамны жилийн үйл ажиллагааны тайлан, үнэлгээнд оруулаагүй болно.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.

Шилэн дансны хөтлөлтийн үнэлгээтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын төсвийн багцад хамаарах хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтэд хийсэн үнэлгээг тайланд оруулаа.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын хөрөнгөөр 2017 оны жилийн эцсийн байдлаар 39,666,710.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төрлийн худалдан авалтад 39,028,020.7 мянган төгрөг зарцуулж, 638,689.3 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын багцын худалдан авах ажиллагааны тайланг Монгол улсын Засгийн газрын 2017 оны 89 дугаар тогтоолоор батлагдсан "Захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээний нийтлэг журам"-ын дагуу үнэлэхэд 94,8 хувийн биелэлттэй дүгнэв.

Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны гүйцэтгэлд хийсэн үнэлгээний тайланг хавсаргав.

3.3. БАЙГУУЛЛАГЫН ШУДАРГА БАЙДЛЫН ТҮВШИНИЙ ҮНЭЛГЭЭ.

Засгийн газрын 2017 оны 389 дүгээр тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 9.9-д заасны дагуу уг үзүүлэлтийг Авлигатай тэмцэх газар /АТГ/-аас гаргаж ирүүлдэг. 2017 онд АТГ-аас төрийн байгууллагуудын шударга

байдлын үнэлгээ хийгдээгүй байна. Иймд яамны 2017 оны үйл ажиллагааны үнэлгээнд оруулаагүй болно.

3.4. ХЭРЭГЛЭГЧИЙН ҮНЭЛГЭЭ.

“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хуулийн 20.1 дэх заалт, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2017 оны А/122 дугаар тушаалаар батлагдсан, “Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам”-ыг тус тус үндэслэн яамны үйл ажиллагаанд Хэрэглэгчийн үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулав.

Хэрэглэгчийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2017 оны 302 дугаар тушаалаар батлагдсан, “Хэрэглэгчийн үнэлгээний ерөнхий удирдамж”-ийн хүрээнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйлчилгээний чанар, хүртээмжийн талаар иргэдээс санал асуулга авах нарийвчилсан удирдамж, ажлын даалгавар, түүвэр судалгаа авах асуулгыг тус тус боловсруулж хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагаанд хийсэн хэрэглэгчийн үнэлгээний түүвэр судалгаанд төрийн байгууллагад ажилладаг 162, салбарын хувийн хэвшилд ажилладаг 342, их, дээд сургуульд ажилладаг 72, нийт 576 хүн хамрагдсан байна.

№	Утга	Тоололт	Хувь
1	Төрийн байгууллага	162	28.1
2	Хувийн хэвшил	342	59.4
3	Их, дээд сургууль	72	12.5
Нийт		576	100

Судалгаанд оролцогчдын насны бүтцийг харвал 10 хувь нь 24 хүртэлх насныхан, 40 хувь нь 25-34 насныхан, 33 хувь нь 35-44 насныхан, 10 хувь нь 45-54 насныхан, 7 хувь нь 55-аас дээш настай иргэд байна. Тэдний 64 хувь нь эрэгтэй, 36 хувь нь эмэгтэйчүүд байсан, 90 хувь нь дээд боловсролтой, үлдсэн 10 хувь нь суурь, бүрэн дунд болон техникийн болон тусгай мэргэжлийн боловсрол эзэмшсэн хүмүүс хамрагджээ

Судалгаанд оролцогчдын 35 хувь нь төрийн байгууллагад, 53 хувь нь хувийн байгууллагад, 5 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 4 хувь нь төрийн бус байгууллагад, 3 хувь нь олон улсын байгууллагад тус тус ажилладаг байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үйл ажиллагааг мэдээллийн хүртээмж, ил тод байдал, эрх зүйн орчны үнэлгээ, бодлого хөтөлбөрүүдийн хэрэгжилт үнэлгээ гэсэн үндсэн 3 бүлэгт 17 асуулгаар түүвэр судалгааг хийлгэв.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд хэрэглэгчийн өгсөн үнэлгээгээр ерөнхий дүн **71,0** %-тай байна.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаас аймгийн Засаг дарга нартай 2017 онд хамтран ажиллах гэрээг 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан. Жилийн эцсийн байдлаар нийт 21 аймгийн Засаг дарга гэрээний биелэлт ирүүлсэн.

Хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан нийтлэг журам, УУХҮС-ын 2017 оны А/122 дугаар тушаалаар баталсан, "Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнг үнэлэх журам"-ын дагуу гүйцэтгэв.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг 84.2 хувьтай дүгнэв.

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРТАЙ БАЙГУУЛСАН ХАМТРАН
АЖИЛЛАХ ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТЭНД ӨГСӨН ҮНЭЛГЭЭ**

/2017 оны жилийн эцэс/

№	Аймгийн нэр	Засаг даргын нэр	Гэрээний дугаар	Заалтын тоо	Дүгнэсэн арга хэмжээний биелэлт, хувь				Дүгнээгүй	Биелэлт, хувь
					100	70	30	0		
1	Архангай	Ц.Мөнхнасан	1	15	10	1	1	-	3	91.6
2	Баян-Өлгий	А.Гылымхан	2	14	6	5	2	-	1	77.7
3	Баянхонгор	Г.Батжаргал	3	11	9	1	-	-	1	97.0
4	Булган	З.Батзориг	4	16	7	7	-	-	2	85.0
5	Говь-Алтай	С.Гансэлэм	5	13	3	7	-	-	3	79.0
6	Говьсүмбэр	Г.Батсуурь	6	15	9	2	-	-	4	94.5
7	Дархан-Уул	С.Насанбат	7	15	10	2	-	-	3	95.0
8	Дорноговь	Т.Энхтүвшин	8	12	9	2	-	-	1	94.5
9	Дорнод	М.Бадамсүрэн	9	15	9	3	-	-	3	92.5
10	Дундговь	О.Бат-Эрдэнэ	10	15	9	2	1	-	3	89.2
11	Завхан	Д.Батсайхан	11	15	8	4	2	-	1	81.4
12	Орхон	Д.Батлут	12	16	3	5	3	-	5	67.3
13	Өвөрхангай	Ц.Ганболд	13	14	8	5	-	-	1	88.5
14	Өмнөговь	Н.Наранбаатар	14	16	11	4	-	-	1	92.0
15	Сүхбаатар	З.Энхтөр	15	15	4	6	2	1	2	73.3
16	Сэлэнгэ	Ш.Оргил	16	15	4	8	-	1	2	73.8
17	Төв	Ж.Батжаргал	17	15	6	8	-	-	1	82.9
18	Увс	Д.Батсайхан	18	9	4	3	1	-	1	80.0
19	Ховд	Д.Галсандондог	19	15	6	6	1	-	2	80.8
20	Хөвсгөл	Л.Ганболд	20	14	4	4	2	-	4	74.0
21	Хэнтий	Н.Ганбямба	21	15	7	5	1	1	1	77.1
НИЙТ										84.2

Аймгийн Засаг дарга нартай байгуулсан, хамтран ажиллах гэрээний биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

IV. БУСАД АСУУДАЛ.

ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖААР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСЛҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам (УУХҮЯ)-ны Геологийн бодлогын газар, Хүнд үйлдвэрийн бодлогын газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар болон Ашигт малтмал, газрын тосны газраас тайлагнасан 7 төслийн тайланд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, төслүүдийн үнэлгээ, санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, төлөвлөсөн ажлын биелэлт, төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын судалгааны тайлан, мэдээг нэгтгэн гаргав.

Хөтөлбөр, төслийн зорилтыг хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах үр дүнг үнэлгээ хийх үед хүрсэн бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулан биелэлтийг хувиар тодорхойлж үнэлгээг гаргав.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд 7 гадаадын зээл, тусламжийн хөтөлбөр, төсөл хэрэгжсэн бөгөөд эдгээрээс 1 төсөл нь буцалтгүй зээлээр, 1 нь өөрсдийн санхүүгийн боломжоор, бусад нь буцалтгүй тусламжаар хэрэгжиж байна.

Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслийн төслийн хэрэгжилт 2017 оны жилийн эцсийн байдлаар 61.4 хувьтай, үүнээс удирдлага зохион байгуулалт

сайн, үр дүн гарсан 1 /90-100 хувь/, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай 3 /70 хувь/, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 3 /40 хувь/ хөтөлбөр, төсөл байна.

**ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ТӨСЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ**

/2017 оны жилийн эцэс/

№	Төслийн нэр	Зорилтын тоо	Үнэлгээ (хувь)					Хэрэгжилт (хувь)
			100	70	40	0	/-/	
1	Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл (MINIS)	4		1				70
2	Тогтвортой бичил уурхай төсөл (ТБУТ) 4-р үе шат	1	1					100
3	Монгол Улсын олборлох салбарын менежментийг бэхжүүлэх (СЕСМИМ) төсөл	1			1			40
4	Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах төсөл (MERIT). Хүний нөөцийн ур чадварт суурилсан тогтолцоо-MERIT	1			1			40
5	Австрали-Монголын эрдэс баялгийн салбарын хамтын ажиллагааны хөтөлбөр /АМЕР/, Веб-д суурилсан Геологийн мэдээллийн метадата-каталоги систем /Монгеокат/-ийг хөгжүүлэх, АМЕП	1		1				70
6	АМГТГ-ын Уул уурхай, газрын тосны төв лабораторийн үйл ажиллагааг дэмжих- К-Петро	1			1			40
7	Монгол орны зүүн болон урд хэсэгт 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх төсөл-КИГАМ	1		1				70
Нийт дүн		10	1	3	3	0	0	61,4

Тайлант хугацаанд Монгол орны зүүн болон урд хэсгээр 1:50 000-ны масштабын геологийн зураглал болон ашигт малтмалын судалгаа хийх чиглэлээр хэрэгжүүлж байгаа БНСУ-ын КИГАМ төслийн хэрэгжилтэнд илүү ахиц гарсан байна. Энэхүү хөтөлбөр, төслийн хүрээнд Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд 1:50000-ны масштабын геологийн зураглал ерөнхий эрлийн ажлыг хийх заавар, тавигдах шаардлагын дагуу амжилттай хийгдсэн.

Хөгжлийн тусламжийн тухай Канад Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд 2016.09.08-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичгийн 7 дугаар зүйл. “Тайлагнах зохицуулалт”-д “Канад Улсын засгийн газар Монгол Улс дахь элчин сайдын яамаараа дамжуулан жилийн тайлан, хараат бус хяналтын тайланг Монгол Улсын Засгийн газарт Сангийн яамаар дамжуулан хүргүүлэх бөгөөд гадаадын тусламжийг хүлээн авах, зарцуулах, удирдах, бүртгэх тайлагнах тухай Монгол Улсын дүрэм, журамтай нийцүүлнэ” хэмээн заасныг үндэслэн Мерит, Сесмим төслүүд нь санхүүжилт, хөрөнгийн зарцуулалт, төлөвлөсөн ажлын биелэлт, төслийн хүрээнд бий болсон ажлын байр, сургалтын судалгаа зэргийг салбарын яам, агентлагт ирүүлээгүй болно.

Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн биелэлтэд 2017 оны жилийн эцсийн байдлаар хийсэн үнэлгээ, тайланг 2018 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 01/557 тоотой Сангийн яаманд хүргүүлж, яамны цахим хуудсанд байршуулан, ил тод байдлыг хангаж ажиллав.

ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ.

Уул уурхай хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Засгийн газрын 2017 оны 20 дугаар тогтоолоор батлагдсан “Алт-2” үндэсний хөтөлбөр хэрэгжиж байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай” хууль, Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн гүйцэтгэв.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2017 оны 17 дугаар захирамжаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдаар ахлуулсан орон тооны бус зөвлөл байгуулагдаж, зөвлөлийн бүрэлдэхүүнд Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Байгаль, орчин аялал, жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 6 төлөөлөл ажиллаж байна

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Байгаль, орчин аялал, жуулчлалын сайд, Монгол банкны ерөнхийлөгчийн хамтарсан 2017.06.14-ний өдрийн А/66/202/А/174/А166 дугаартай тушаалаар “Алт-2” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөөг баталсан. Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан нийт 49 үйл ажиллагааг төрийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж зэрэг 38 гаруй хуулийн этгээд хэрэгжүүлэхээс Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам 46 үйл ажиллагааны хэрэгжилтэнд оролцож, 38 үйл ажиллагааг толгойлон хэрэгжүүлж ажиллаж байна.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээгээр 13 үйл ажиллагаа 100 хувь, 24 үйл ажиллагаа 70 хувь, 4 үйл ажиллагаа 40 хувиар тус тус дүгнэгдсэн. Байгаль орчин, аялал, жуулчлалын яамны толгойлон хэрэгжүүлж байгаа зорилт 3-ын 6 дугаар, зорилт 4-ийн 3 дугаартай 8 үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнаагүй тул дүгнээгүй болно.

**“АЛТ-2” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ**

/2017 оны жилийн эцэс/

Зорилтын дугаар	Арга хэмжээ, үйл ажиллагааны тоо			Хэрэгжилтэнд өгсөн үнэлгээ (хувь)					Хэрэгжилт (хувь)
	ХАХ	ТАХ	ТҮА	100	70	40	0	/-/	
Зорилт 1	12	12	12	4	7	1	0	0	77,50
Зорилт 2	5	5	5	2	2	1	0	0	76,00
Зорилт 3	12	12	15	4	5	2	0	4	75,40
Зорилт 4	8	8	11	0	7	0	0	4	70,00
Зорилт 5	6	6	6	3	3	0	0	0	85,00
Нийт дүн	43	43	49	13	24	4	0	8	76,59

Тайлбар: 3-хөтөлбөрийн зорилтын тоо, ХАХ-хөтөлбөрийн арга хэмжээний тоо, ТАХ-ерөнхий төлөвлөгөөний арга хэмжээний тоо, ТҮА-ерөнхий төлөвлөгөөний үйл ажиллагааны тоо, /-/үнэлэх боломжгүй.

“Алт-2” үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр зорилт 77.5 хувь, 2 дугаар зорилт 76 хувь, 3 дугаар зорилт 75.4 хувь, 4 дүгээр зорилт 70 хувь, 5 дугаар зорилт 85 хувийн биелэлттэй буюу 2017 оны жилийн эцсийн байдлаар хөтөлбөрийн **76.59** хувиар дүгнэсэн.

V. ДҮГНЭЛТ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан зорилт, арга хэмжээ, УИХ, Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах, салбарын хууль тогтоомж, бодлого, стратеги боловсруулах, хэрэгжүүлэх, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төсвийн болон хөрөнгө оруулалтын зарцуулалтын үр дүн, салбарын үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангах зэрэг асуудалд өргөн хүрээтэй хандаж, 2017 онд төлөвлөсөн үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүллээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2017 оны үйл ажиллагааны үр дүнгийн биелэлт **89,3%**-тай, ерөнхий үнэлгээ **4,46** оноогоор “сайн” дүнтэй дүгнэв.

VII. ЗӨВЛӨМЖ

Бодлогын зорилтын хэрэгжилтийн талаар:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны эрхлэх асуудлаар нийт 105 арга хэмжээ, үүнээс 76 арга хэмжээг яам толгойлон, 28 арга хэмжээг бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан. Хамтран хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээний биелэлт гаргахад бэрхшээлтэй, тухайн асуудлаар санал авах, хамтран ажиллах талаар үндсэн хэрэгжүүлэгч байгууллагаас ханддаггүй зэрэг бэрхшээл гарч байгааг анхаарч толгойлон хэрэгжүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллах талаар яамны зүгээс санаачлага гарган ажиллах;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан зорилт арга хэмжээний биелэлтийг гаргахдаа тухайн зорилтын хүрээнд хийгдсэн ажил, явцын мэдээлэл, гарсан шийдвэр, хүрсэн үр дүнгийн түвшинг товч тодорхой, гүйцэд тайлагнах, тухайн тайлант хугацаанд хийж гүйцэтгэсэн арга хэмжээний биелэлт гаргаж ирүүлэх тал дээр нэгжийн удирдлага, мэргэжилтнүүд онцгой анхаарч ажиллах;
- Хууль тогтоомжийн биелэлтэд тухайн шийдвэр заалтыг хэрэгжүүлсэн ажил, авсан арга хэмжээний талаар товч, тодорхой биелэлт гаргах, холбогдох тушаал шийдвэрийн огноо дугаар, агуулгыг дурдаж байх, бүрэн хэрэгжсэн гэж үзвэл уг шийдвэр заалтыг хяналтаас хасуулах саналын хамт гаргаж ирүүлж хэвших. Төрийн захиргааны удирдлагын газрын зүгээс тогтоол шийдвэр хяналтанд авагдсан тухай бүр тэдгээрийг бүх албан хаагчдад хүргүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авах нь зүйтэй байна.

Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн талаар:

- Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээ, гэрээний хавсралт болох яамны жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тухайн жилд хэрэгжүүлэх арга хэмжээ, ажил үйлчилгээний шалгуур үзүүлэлт /тоо хэмжээ, хугацаа, чанар/-ийг оновчтой төлөвлөж, уг ажил үйлчилгээг эзэнжүүлэх, биелэлтийг шалгуур үзүүлэлттэй нь уялдуулан тайлагнах;
- Ажил үйлчилгээний биелэлтийг бичмэл хэлбэрээс гадна зураг, дүрс, график ашиглан тайлагнахад анхаарах шаардлагатай.

Байгууллагын нээлттэй байдлын талаар:

- Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлтийг ерөнхий агуулгатай гаргаж байгаа тул цаашид шалгуур үзүүлэлт /"Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хуулийн заалт/-ийг хангах хүрээнд тухайн тайлант жилийн хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажлын талаар тоо баримттай, огноо дугаартай тодорхой биелэлт гаргаж байх тал дээр анхаарах шаардлагатай.

Үйл ажиллагааны үр дагаварын талаар:

- Яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн шалгуур үзүүлэлт тусгагдсан суурь болон зорилтот түвшний тоон үзүүлэлтийг бодлогын баримт бичгүүдэд тусгасан тоон болон чанарын үзүүлэлттэй уялдуулж төлөвлөх, тухайн тайлант жилд хүрсэн түвшинг үнэн зөв гаргаж байхад бодлогын газрууд анхаарч ажиллах;

**УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН
(2017 он)**

Үзүүлэлт		Хувь	Жин	Оноо
1	2	3	4	5
Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт	90,6	0.6	4,46
	2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт	68,4		
	3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт	88,4		
	4. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээ	97,0		
Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	1. Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт	98,8	0.2	
	2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт	100		
Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	1. Байгууллагын ил тод байдлын үнэлгээ	100	0.2	
	2. Шилэн дансны хөтөлөлтийн үнэлгээ /СЯ/	/-/		
	3. Шударга байдлын түвшний үнэлгээ /АТГ/	/-/		
	4. Хэрэглэгчийн үнэлгээ	71,0		
Ерөнхий үнэлгээ:		89,3	0,89	

VI. ХАВСРАЛТ

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны биелэлт,
- Байгууллагын ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн биелэлт,
- Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн биелэлт
- Төсвийн ерөнхийлөн захирагчаас аймгийн засаг дарга нартай байгуулсан хамтран ажиллах гэрээний биелэлт,
- Хүний нөөцийг чадавжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлт,
- “Хэрэглэгчийн үнэлгээ”-ний тайланг тус тус хавсаргав.

Хянасан:

ХШУДАГ-ын дарга

Ц.Одхүү

Нэгтгэн боловсруулсан:

Ахлах мэргэжилтэн

Б.Баяржаргал /2018.03.29/

ХШҮ хийж, тайлан

боловсруулсан:

Ахлах мэргэжилтэн

Н.Баатар

Мэргэжилтэн

С.Цэцэг-Өлзий

Х.Цэнд-Аюуш

Д.Батнайрамдал

Н.Цогтбаяр

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2018 он